



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/178/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх
Утас: 7033-3019

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.19 № 21
танай _____-ны № _____-т

ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Төвшрүүлэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын нягтлан бодогч солигдсон бөгөөд тайлангийн жилийн дараа төсөв захирагч солигдсон байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 107, 489, 491 дүгээр тогтоол, 2023 оны 241 дүгээр тогтоол, Архангай аймгийн Засаг даргын А/74 дүгээр захирамжийн дагуу төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой цалингийн сан 38.8 хувиар нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 үндсэн зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 80.0 хувиар үнэлжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,835,391.00	2,682,391.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,835,391.00	2,682,391.00
35400	Хангамжийн материал	1,835,391.00	2,682,391.00
35410	Бичиг хэргийн материал	314,000.00	454,000.00
35420	Аж ахуйн материал	1,521,391.00	2,228,391.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,289,375.19	1,897,026.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,289,375.19	1,897,026.83
39200	Биет хөрөнгө	2,134,375.19	1,777,026.83
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,858,800.00	5,496,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,429,400.04	-3,298,466.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,894,085.80	8,894,085.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,189,110.57	-9,315,392.21
39300	Биет бус хөрөнгө	155,000.00	120,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-145,000.00	-180,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,124,766.19	4,579,417.83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,124,766.19	4,579,417.83
51	Засгийн газрын хувь оролцоо	4,124,766.19	4,579,417.83
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,426,540.00	3,426,540.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	3,426,540.00	3,426,540.00
51200	Хуримтлагдсан үр дүн	399,964.59	854,616.23
51210	Өмнөх үеийн үр дүн	2,612,397.31	399,964.59
51220	Тайлант үеийн үр дүн	-2,212,432.72	454,651.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,261.60	298,261.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,124,766.19	4,579,417.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	154,729,600.00	119,966,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	154,729,600.00	119,966,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	154,729,600.00	119,966,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	154,729,600.00	119,966,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	156,942,032.72	119,511,348.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,942,032.72	119,511,348.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	93,463,902.72	109,493,351.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,742,130.00	75,735,634.20
210101	Үндсэн цалин	37,607,955.00	52,248,015.37
210102	Нэмэгдэл	6,555,686.00	9,841,358.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3,730,000.00
210104	Урамшуулал	1,578,489.00	9,916,260.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,716,540.00	9,757,468.88
210201	Тэтгэврийн даатгал	3,978,242.74	6,588,149.98
210202	Тэтгэмжийн даатгал	434,833.60	775,076.46

210203	ҮОМШӨ-ний даатгал	347,866.88	692,549.54
210204	Ажилгүйдлийн даатгал	85,929.74	151,539.64
210205	Эрүүл мэндийн даатгал	869,667.04	1,550,153.26
2104	Хангамж, бараа материалын зардал	7,729,600.00	4,937,900.00
210401	Бичиг хэрэг	1,122,750.00	799,800.00
210402	Тээвэр, шатахуун	6,386,850.00	3,738,100.00
210404	Ном, хэвлэл	220,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	37,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	37,000.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	700,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,694,070.00	8,495,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,694,070.00	7,995,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,081,562.72	9,830,348.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,265,880.00	6,700,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,615,682.72	3,030,348.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,478,130.00	10,017,996.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,397,900.00	1,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,312,200.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,096,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,989,400.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,080,230.00	8,617,996.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,080,230.00	8,617,996.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-2,212,432.72	454,651.64
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,212,432.72	454,651.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	154,729,600.00	119,966,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	154,729,600.00	119,966,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	154,729,600.00	119,966,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	154,729,600.00	119,966,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	154,729,600.00	117,328,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	154,729,600.00	117,328,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	91,251,470.00	107,310,003.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,742,130.00	75,735,634.20
210101	Үндсэн цалин	37,607,955.00	52,248,015.37
210102	Нэмэгдэл	6,555,686.00	9,841,358.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3,730,000.00
210104	Урамшуулал	1,578,489.00	9,916,260.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,716,540.00	9,757,468.88
210201	Тэтгэврийн даатгал	3,978,242.74	6,588,149.98
210202	Тэтгэмжийн даатгал	434,833.60	775,076.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	347,866.88	692,549.54

210204	Ажилгүйдлийн даатгал	85,929.74	151,539.64
210205	Эрүүл мэндийн даатгал	869,667.04	1,550,153.26
2104	Хангамж, бараа материалын зардал	5,900,000.00	4,954,900.00
210401	Бичиг хэрэг	700,000.00	966,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00	3,588,100.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	362,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	362,000.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	700,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,902,970.00	9,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,902,970.00	8,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,489,830.00	6,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,289,830.00	6,700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,478,130.00	10,017,996.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,397,900.00	1,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,312,200.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,096,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,989,400.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,080,230.00	8,617,996.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,080,230.00	8,617,996.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	2,638,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	2,638,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	2,638,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	2,638,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	2,638,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-2,638,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	2,612,397.31	6,337,198.91
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	2,612,397.31	6,337,198.91
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-2,212,432.72	-2,212,432.72
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	399,964.59	4,124,766.19
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	399,964.59	4,124,766.19
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	399,964.59	4,124,766.19

19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	454,651.64	454,651.64
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	3,426,540.00	298,261.60	854,616.23	4,579,417.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,966,000.00	111,348,003.08	8,617,996.92	92.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	119,966,000.00	111,348,003.08	8,617,996.92	92.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	118,566,000.00	109,948,003.08	8,617,996.92	92.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	82,291,400.00	75,735,634.20	6,555,765.80	92.03
210101	Үндсэн цалин	82,291,400.00	52,248,015.37	30,043,384.63	63.49
210102	Нэмэгдэл	0.00	9,841,358.00	-9,841,358.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3,730,000.00	-3,730,000.00	0.00
210104	Урамшуулал	0.00	9,916,260.83	-9,916,260.83	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,286,500.00	9,757,468.88	529,031.12	94.86
210201	Тэтгэврийн даатгал	6,994,900.00	6,588,149.98	406,750.02	94.19
210202	Тэтгэмжийн даатгал	822,900.00	775,076.46	47,823.54	94.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	658,300.00	692,549.54	-34,249.54	105.20
210204	Ажилгүйдлийн даатгал	164,600.00	151,539.64	13,060.36	92.07
210205	Эрүүл мэндийн даатгал	1,645,800.00	1,550,153.26	95,646.74	94.19
2104	Хангамж, бараа материалын зардал	4,954,900.00	4,954,900.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	966,800.00	966,800.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	3,588,100.00	3,588,100.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	400,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	700,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	700,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,533,200.00	9,000,000.00	1,533,200.00	85.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,033,200.00	8,500,000.00	1,533,200.00	84.72
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,800,000.00	6,800,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.00	100,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,700,000.00	6,700,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,400,000.00	1,400,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,400,000.00	1,400,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,400,000.00	0.00	100.00

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	119,966,000.00	111,348,003.08	8,617,996.92	92.82
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	96,466,000.00	111,348,003.08	-14,882,003.08	115.43
320001	Орон нутгийн төсвөөс	96,466,000.00	111,348,003.08	-14,882,003.08	115.43
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	23,500,000.00	0.00	23,500,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	23,500,000.00	0.00	23,500,000.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3.00	3.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	0.00	100.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийг Төвшрүүлэх сумын ИТХ-ын 2023.01.18-ны өдрийн 01 тоот албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлж, хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байгаа тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнд нөлөөлөөгүй болно.

Аудитаар алдаа илрээгүй бөгөөд нийт 3,926.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,926.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудал нь материаллаг бус бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 1,199.6 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тус байгууллага нь дотоод хяналтын нэгжгүй, тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах албан шаардлага хүргүүллээ.

5.2.2 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг нягтлан шалгахад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 9 нэр төрлийн 3,926.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Журмын дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй		Т	Д
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
											-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотоод хяналттай холбоотой	1	-			1	-						
Элэгдлээ нөхсөн хөрөнгөтэй холбоотой	1	3,926.1	-	-	1	3,926.1	-	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-